## 2023 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(Аймгийн Засаг даргын Тамгын газар)

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр | Мандалговь хот

| Бүтэц | № | Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зарцуулсан төсөв | Хэмжих нэгж | Суурь түвшин | Төлөвлөсөн онд хүрэх түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2023 | | |
| | *Ерөнхий чиг үүргийн нэр: 1.* **Байгалийн баялаг, байгаль орчин, аялал жуулчлал** | | | | | | | | |
| | *Үндсэн чиг үүргийн нэр: 1.* **Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Төв суурин газрын орчны бохирдлын түвшин бууруулна. | Агаарын чанарын индексийн түвшин | | Индекс | 0 | 100> | Мандалговь хотын агаарын чанарыг индексээр үнэлэхэд 26 буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна. | 100 |
| | | | Бохирдсон хөрсний талбайн хэмжээ /бууралт/ | | га | 205 | 113 | Төвлөрсөн хогийн цэгийн 116.9 га талбайгаас Цагаандэлгэр сум 7 га, Эрдэнэдалай сум 2 га нийт 9 га талбайг шууж булшлан 107.9 га болгож бууруулсан. | |
| Арга хэмжээ | 1 | Утаа бага ялгаруулах төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх | 15 квт-аас дээш хүчин чадалтай зуухны тоо | | тоо | 2 | 4 | 2022 оны 9 сард БОАЖЯам Кан Мэй Хуан Бао ХХК-тай гэрээ байгуулан аймгийн 10 нам даралтын зууханд утаа шүүгч суурилуулахаар гэрээ байгуулан гэрээний дагуу 2023 онд суурилуулсан. Одоогоор нийт 17 зууханд утаа шүүгч суурилуулсан. Утааг шүүгчийг суурилуулснаар агаар бохирдуулагч эх үүсвэрээс гарах бохирдлыг 20%-иар бууруулах боломжтой. Эдгээр шүүлтүүрийг 12 сард улсын комисс хүлээж авахаар төлөвлөсөн. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Нам даралтын зуухны тоог бууруулах | Нам даралтын зуухны бууралт | | тоо | 80 | 65 | Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгаль орчны салбар байгууллагууд болон Авто тээврийн үндэсний төв гэсэн бүрэлдэхүүнтэйгээр томилогдож ажилласан. Нам даралтын зуух 2022 онд 69 байснаас 5-аар багассан үзүүлэлттэй. | 90 |
| | 3 | Гэр хорооллын бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонг нэмэгдүүлэх | Гэр хорооллын сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь | | Хувь | 28 | 36 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Айл өрх бүр эко ариун цэврийн байгууламжтай болцгооё" аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж Сайнцагаан сумын 5 багийн 200 иргэнд нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүд, ногоон зээлийн талаарх мэдээллийг хүргэсэн. Сайнцагаан суманд эко жорлонгийн кольцо үйлдвэрлэгч Мягмарсүхтэй хамтран видео контент бэлтгэж байгууллагын цахим хуудас, аймгийн зарын групп, хашаандаа сайхан амьдаръя зэрэг группүүдэд нийтэлж нийт 3500 иргэнд сурталчилсан. Гэр хороололд стандартын шаардлага хангасан 95 нүхэн жорлон нэмэгдсэн. | 100 |
| | 4 | Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | Цэвэрлэсэн талбайн хэмжээ | | Га | 325 | 300 | БОАЖЯСайдын 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" нийтийн эзэмшлийн талбай цэвэрлэх аяныг зарлаж сумд, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд аяны удирдамжийг хүргүүлж ажилласан. Аяны хүрээнд 10 байгууллага Сайнцагаан сумын нийтийн эзэмшлийн 10 талбайн 15 тн хогийг цэвэрлэж албан байгууллага иргэдийг цахимаар уриалсан. Сумдад нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж нийтийн эзэмшлийн 2775,8 га талбайн 815,4 тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн төвлөрсөн цэгт шилжүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5 | Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах | Тухай жилд шууж булшилсан талбайн хэмжээ | | Га | 35 | 10 | Нийтийн эдэлбэр газарт ил задгай зөвшөөрөлгүй асгасан хог болон төвлөрсөн хогийн цэгийг шууж булшлах ажлыг Сайнцагаан 4 га, Адаацаг 0,2 га, Говь-Угтаал 3 га, Гурвансайхан 36 га, Дэлгэрцогт 2,5 га, Луус 6,8 га, Өлзийт 5 га, Цагаандэлгэр 1 га, Хулд 3 га, Эрдэнэдалай 16 га нийт 10 сумын 77.5 га талбайг шууж булшилсан. | 100 |
| | 6 | Ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх | Нэмэгдүүлсэн хогийн савны тоо | | Тоо | 25 | 300 | БОАЖСайдын 02 албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулан 15 сумдад хүргүүлсэн. Сайнцагаан сумын ангилан ялгах хогийн савгүй авто засварын 7, банк 4, хэвлэлийн 2, шатахуун түгээх станц 13 нийт 26 ААНэгж, байгууллагад ангилан ялгах хогийн савтай болох тухай албан бичгийг хүргүүлсэн. Дэрэн сумд 5, Адаацаг сумд 5, Сайхан-Овоо сумд 8, Цагаандэлгэр сумд 2, Сайнцагаан сумын өрхийн эмнэлэг 3, Хүүхдийн тоглоомын талбайд 10, Авто тээврийн үндэсний төв, Монгол банк, Нийгмийн даатгалын хэлтэс, Номин дэлгүүр зэрэг ААНэгж, байгууллагуудад 50 ширхэг нэмэгдэж, нийт ангилан ялгах хогийн савны тоо 311-д хүрсэн. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:2.* Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 28 хувь байсныг 2024 онд 44 хувьд хүргэнэ. | Цэвэршүүлсэн усаар хангагдсан хүн амын эзлэх хувь | | хувь | 28 | 40 | Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай, Адаацаг, Гурвансайхан сумдад ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулснаар төв суурин газрын хүн амын 46 хувь нь шаардлага хангасан цэвэршүүлсэн ундны усны эх үүсвэрээр хангагдсан. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах | Тухайн жилд суурилуулсан төхөөрөмжийн тоо | | тоо | - | 2 | Хүн амын унд ахуйн эх үүсвэр дээр усны дүн шинжилгээнд нийцсэн ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын стандартыг хангасан тус бүр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай сумдад тус бүр 1, Адаацаг сумд 2, нийт 4 сумын 5 ундны усны эх үүсвэр дээр суурилуулсан. | 100 |
| | 2 | Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс | Тэмдэгжүүлсэн бүлгийн тоо | | тоо | - | 80 | Усны сан бүхий газарт тэмдэг, тэмдэглэгээг Адаацаг 21, Гурвансайхан 7, Сайхан-Овоо 2, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах | | | | | | Хулд 2, Өндөршил 3, Эрдэнэдалай 4, нийт 6 сумын 39 булгийн онцгой хамгаалалтын бүсэд байршуулж, аймгийн хэмжээнд нийт 98 булгийн онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэв. Тэмдэгжүүлэлд хийснээр онцгой хамгаалалтын бүсэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдохгүй. | |
| | 3 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | Хашсан булгийн тоо | | тоо | 53 | 62 | Адаацаг сумын "Баянхошууны булаг", Хулд сумын "Балын булаг", Сайхан-Овоо сумын "Дэлгэрэхийн булаг" Гурвансайхан сумын Илжгэнд нийт 4 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 2-ны А/571 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авсан. 4 булгийн эхийг хашиж хамгаалснаар 14 өрхийн бог, бод нийлсэн 17000 мал ундаалах нөхцөл бүрдэж бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж нийт хашсан булгийн тоо 63 болж өссөн үр дүнтэй. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:3* Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 569.4 га-д хүргэж, ургалтын хувийг нэмэгдүүлнэ. | Ногоон байгууламжийн хэмжээ | | га | 369.4 | 519.4 | Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Сайнцагаан сумд 18 га, авто зам дагуу 25 га, ногоон говь төслөөр 2 га, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг 3 га, Сайнцагаан сумын "Аривжих төгөл"-д шинээр 2 га, нийт 50 га талбайд ойжуулалт, ойн зурвас байгуулж 82.3 хувьтай ургуулав. Аймгийн хэмжээнд ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ нийт 519.9 га-д хүрсэн. | 100 |
| | | | Ургалтын хувь | | Хувь | 75 | 78 | | |
| Арга хэмжээ | 1 | Тухайн жилийн сумдын ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламж хийх газрын байршил, талбайн хэмжээг тусган батлуулах | Батлуулсан сумын тоо | | Тоо | 15 | 15 | 2023 оны сумдын тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламжийн зориулалтаар 19 байршилд 475.73 га, мод үржүүлгийн зориулалтаар 2 байршилд 6 га, нийт 481.73 га газрыг тусган батлуулсан. | 100 |
| | 2 | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Тухайн жилд нэмэгдсэн ногоон байгууламжийн хэмжээ | | Га | 5 | 5 | Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Сайнцагаан сумд нийт 18 га талбайд ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд гэрээ байгуулж 4 төрлийн 12800 мод сөөг тарьж цэнэг усалгаа хийсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Иргэн, ААН байгууллагыг өөрийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод сөөг тарих ажлыг зохион байгуулах | Жилд тарьсан модны тоо | | Тоо | 13845 | 27000 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговио ногоорууль я” хөтөлбөрийн хүрээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өссөн. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:4 Газрын доройтлыг бууруулах, байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2020 онд 8.3 байсныг 2024 онд 24.6 хувь болгоно. | Нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь | | Хувь | 8.3 | 20.5 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ 2020 онд 51 га буюу 8.3 хувийг эзэлж байсан. 2023 оны байдлаар нийт 171.2 га-д буюу 27 хувьд хүрсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 80 га-р нэмэгдүүлэх | Техникийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | Хувийн хэвшил 23.0 сая | Га | 79.6 | 139.6 | Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг ААНэгжүүдээс Өлзийт, Баянжаргалан, Гурвансайхан, Сайнцагаан, Дэлгэрхангай сумдад 13 ААНэгж, 15 байршилд нийт 23.68 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэж, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 144.7 га-д хүрсэн. | 100 |
| | 2 | Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 20 га-р нэмэгдүүлэх | Биологийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | Хувийн хэвшил 0.8 сая | Га | 1 | 16 | 2022 онд биологийн нөхөн сэргээлт 24.74 га-д хүрсэн ба 2023 онд Дэлгэрхангай сумд 0.2, Баянжаргалан сумд 1,62 га талбайд хийгдсэнээр нийт биологийн нөхөн сэргээлтийн хэмжээ 26.52 га-д хүрэв. | 100 |
| | 3 | Уул уурхайн төслийн байгаль орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх | үр өгөөжийг нэмэгдүүлсэн төслийн тоо | Хувийн хэвшил 21.0 сая | Тоо | 5 | 20 | Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны өмнө хүлээх хариуцлага, үүргийг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж буй 6 сумд 17 дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөж, эвдэрч эзэнгүй орхигдсон 5.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 9350 ширхэг мод тарьж, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 12 ширхэг камер, 1 худагт амьтан услах сан байршуулж биотехникийн арга хэмжээ авч ажилласан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Нийт 12 ААНэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дүйцүүлэн хамгааллын 21 арга хэмжээг хэрэгжүүлсэн. | |
| | 4 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах | Нэгдсэн хяналт шалгалтын тоо | | тоо | 1 | 2 | Гурвансайхан сумын Өндөр-Элст гэх газарт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй "Жеймэр сурвэй" ХХК ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна гэх нутгийн иргэдийн гомдлоор экологийн цагдаагийн алба, уул уурхайн байцаагчдын хамтарсан хяналт, шалгалт хийж үйл ажиллагааг зогсоосон. Баянжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг "Монголросцветмет" ХХК-д гаргасан иргэний гомдлын дагуу хяналт шалгалт хийж 4 зөрчлийг илрүүлэн улсын байцаагчийн албан шаардлага өгч зөрчлийг бүрэн арилгасан. Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг уул уурхайн 39 аж ахуйн нэгжид хийж ажилласан. Нийт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт бус 2, төлөвлөгөөт 1, нийт хууль хяналтын байгууллагатай хамтарсан 3 удаагийн хяналт шалгалтаар 41 аж ахуйн нэгжид илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 9 албан шаардлага хүргүүлж торгуулийн арга хэмжээ авсан. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 5* Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ. | Нийт газар нутагт эзлэх хувь | | хувь | 27 | 33.1 | Өлзийт сумын "Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан Суварга" орчмын 336,490,8 га талбайг улсын тусгай хамгаалалтад авхуулахаар сум, аймгийн тогтоол гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Сайнцагаан сумын Тэвш хайрхан, Улаан шанд, Нарангийн жасын туурь, Авдрантын хүнхрийн хөшөө орчмын 242723.07 га талбайг сумын ИТХурлын 13 дугаар тогтоолоор газар нутгийг өргөтгөн шинэчлэн батлав. Ингэснээр улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нутгийн хэмжээ 33.4 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн. | |
| Арга хэмжээ | 1 | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | Улсын тусгай хамгаалалттай нутгийн хувь | | хувь | 5.7 | 10.2 | Өлзийт сумын "Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан суварга" орчмын 336,490,8 га талбайг улсын тусгай хамгаалалтад авахаар сум, аймгийн тогтоол гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Ингэснээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 10.2 хувь болж нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн. | 70 |
| | 2 | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хувь | | хувь | 21.3 | 22.9 | Сайнцагаан сумын Тэвш хайрхан, Улаан шанд, Нарангийн жасын туурь, Авдрантын хүнхрийн хөшөө орчмын 242723.07 га талбайг сумын ИТХурлын 13 дугаар тогтоолоор газар нутгийг өргөтгөн шинэчлэн баталж орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 22.3 хувиас 23.2 хувь болж нэмэгдэв. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 6 Биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалах*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Биологийн олон янз байдлын нөөцийг хамгаалах, арга хэмжээний тоог нэмэгдүүлэх | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | | Тоо | 13 | 31 | Тус аймгийн улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт байрлах 6 агнуурын бүсэд 35 боодол өвс, 8 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ 45 удаа авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэрэгт хяналт тавьж ажилласан.<br>"Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газарт 2023 онд 50 тарвага нутагшуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Идлэг шонхор шувууны үржлийг дэмжих, хамгаалах зорилгоор өндөр хүчдэлийн шонгоос хамгаалж Өлзийт сумд 9 суултуур, Говь-Угтаал сумд 7 суултуур хийж байршуулсан. Нийт биологийн олон янз байдлын нөөцийг хамгаалах чиглэлээр 47 удаагийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж, | Биотехникийн арга хэмжээ | ОНТ 1.8 хувийн | Тоо | 10 | 28 | Тус аймгийн улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт байрлах 6 агнуурын бүсэд 35 боодол өвс, 8 тонн хужир, мараа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | идэш тэжээлийн хомсдолоос үүссэн зүй бус хорогдлоос сэргийлж, биотехникийн арга хэмжээ авах | | хэвшил 2.0 | | | | тавьж зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулж 45 удаа биотехникийн арга хэмжээг авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах хөдөлгөөнт камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан агнуур хийхээс урьдчилан сэргийлж, хяналт тавьсан. | |
| 2 | Тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулах | Тухайн жилд нутагшуулсан тарваганы тоо | | тоо | 30 | 50 | "Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор Эрдэнэс монгол ХХК-ны хөрөнгө оруулалтаар "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газарт 50 тарвага нутагшуулсан. | 100 |
| 3 | Аймгийн хэмжээнд биологийн олон янз байдлын тооллого, судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Тооллого хийгдсэн эсэх | | /Тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтын ерөнхий судалгаа, агнуурын менежментийн төлөвлөгөө судалгааны мэргэжлийн байгууллага болох "Эко үйлчилгээ" ТББ-аар хийж гүйцэтгүүлсэн. Тус судалгаа нь 5 жилд нэг удаа хуулийн дагуу хийгддэг бөгөөд үүний үр дүнд тусгай болон ахуйн зориулалтын агнуурын зөвшөөрөл олгогдох боломжтой болсон. | 100 |
| | | Судалгаа хийгдсэн эсэх | | /Тийм-1, үгүй-0/ | 1 | - | Ургамлын төрөлжсөн жишиг плантаци байгуулах зорилгоор Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд ашигт ургамлын жагсаалтад орсон Цулбуурт цахилдаг, Чихэр өвс зэрэг ургамлыг тарималжуулж, өсөлтийн өндөр 1.8-5.6 см ургуулсан. | |
| 4 | Байгалийн ашигт ургамлыг хамгаалж, тарималжуулах | Тухайн жилд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | | Тоо | - | 1 | Тус аймгийн улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт байрлах 6 агнуурын бүсэд 35 боодол өвс, 8 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдын биотехникийн арга хэмжээ 45 удаа авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэрэгт хяналт тавьсан. "Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор "Их газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газарт 2023 онд 50 тарвага нутагшуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт биологийн олон янз байдлын нөөцийг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамгаалах чиглэлээр 47 удаагийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. | |
| | **Үндсэн чиг үүргийн нэр: 7 Аялал жуулчлалыг хөгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гадаад, дотоод жуулчдын тоог 40000-д хүргэнэ. | Тухайн жилийн жуулчдын тоо | | тоо | 19.5 | 31.0 | Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нэвтрэх цэг болон зочид буудал, жуулчны бааз, сувилал, гэр буудал, эвент арга хэмжээний нэгтгэсэн дүнгээр гадаад, дотоодын 79316 жуулчин ирсэн. Өмнөх оноос гадаад, дотоодын жуулчид 1 дахин өссөн үзүүлэлттэй. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Аялал жуулчлалын гол бүс нутгийг түшиглэсэн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжиж, хүчин чадлыг нэмэгдүүлэх | Жуулчин хүлээн авах хүчин чадал | | Ор хоног | 1004 | 1150 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газарт байгуулагдсан Говь хулан жуулчны бааз 70 хүн хүлээн авах хүчин чадалтай ресторан байгуулагдсан. Аймгийн төвд зам дагуу боловсон ариун цэврийн байгууламжтай 20 ор хоногтой гэр буудал, Ашид зочид буудал өргөтгөл хийж 4 өрөө 8 ор хоног нэмэгдэж, аймгийн хэмжээнд ор хоногийн тоо 1168-д хүрэв. | 100 |
| | 2 | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх | Стандартын хэрэгжилтийн үнэлгээ | | Хувь | 80 | 88 | Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран Дундговь аймгийн хэмжээнд жуулчны баазын үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдэд хяналт шалгалт зохион байгуулж шалгалтад Өлзийт, Сайхан-Овоо, Адаацаг, Дэлгэрцогт сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 13 жуулчны бааз, 10 гэр баазын үйлчилгээ эрхлэгч нар хамрагдсан. Хяналт шалгалтаар Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө байхгүй, Тохирлын гэрчилгээгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил дутагдлууд илэрсэн. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулан, тохирлын үнэлгээнд хамруулж баталгаажуулалтад хамруулахаар болсон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Энэ онд “Эрдэнэ-Ухаа” ХХК, “Этернал хоризон” ХХК, “Онгийн нууц” ХХК-ийн жуулчны баазуудын тохирлын гэрчилгээний хугацаа дуусаж, сунгуулах хүсэлт гаргаж MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу үнэлгээ хийхэд тус газруудын дундаж үнэлгээ 88%-тай үнэлэгдэн, тохирлын гэрчилгээ олгосон. | |
| 3 | Жуулчдын голлон зорих газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах | Байгуулагдсан отоглох цэгийн тоо | | Тоо | 1 | 4 | 2022 онд Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт “отоглох цэг” байгуулсан. Аймгийн хэмжээнд Цагаан суваргад 1, Их газрын чулуунд 2, нийт 3 газарт отоглох цэг байгуулсан. Энэ онд отоглох цэгийн менежмент хариуцагчийг шалгаруулж гэрээ байгуулж Цагаан суварга отоглох цэгт 122 машин 284 аялагч, Их газрын чулууны отоглох цэгт 162 машины 346 аялагч жуулчдад үйлчилсэн. | 100 |
| 4 | Олон улсын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчлах | Тухайн жилд жуулчин хүлээн авахаар байгуулсан гэрээний тоо | | Тоо | 100 | 300 | ITM 2023 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Говийн шуранхай АЖхолбоо, Цагаан суварга, Эрдэнэ-Ухаа, Баянбулаг, Онги-Энержи, Бага газрын чулуу, Говь хулан, Онгийн нууц, Сүм хөх бүрд, Ачлал-Оргил, Бага газрын хүрээ гэсэн 12 аж ахуйн нэгж, байгууллага нэгдсэн зохион байгуулалттай оролцож, тур оператор компаниудтай 2024 онд жуулчин хүлээн авах 634 гэрээ байгуулж, 5850 сурталчилгааны материал тарааж орон нутгаа сурталчлан ажилласан. | 100 |
| 5 | Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлэх | Цахим үйлчилгээнд хамрагдсан ААН-ийн тоо | ОНТ 12.0 сая | Тоо | - | 15 | Айхотел ХХК-тай гэрээ байгуулж “Dundgovi” аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформыг 2 удаа хэлэлцүүлж хүлээн авсан. Цахим платформд 96 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл орж, 204 иргэн гар утсандаа татаж суулгасан. Гар утасны хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зорилгоор байгууллагаар үйлчилгээ авч байгаа иргэдэд мэдээлж, хулдаасан хэвлэл хөлтэй самбар байршуулан тогтмол сурталчлан ажилласан. Орон нутгийн төсвийн 12.0 сая төгрөгийг зарцуулав. | |
| 6 | Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн уламжлалт, өв соёлын эвент арга хэмжээ зохион байгуулах | Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо | ОНТ 30.0 сая | Тоо | 1 | 3 | Тус аймгийн Хулд сумд 1 дүгээр сарын 27-ны өдөр "Тэмээний өв соёл" эвент арга хэмжээг зохион байгуулж, Өмнөговь аймгийн 7 сум, Дундговь аймгийн 3 сумын тэмээчид оролцож, гадаад, дотоодын 518 жуулчид бүртгэгдсэн. Цагаан суварга дахь "Говь караvансерай" жуулчны баазтай хамтран "Сэтгэшгүй оддын чуулган" эвент арга хэмжээг зохион байгуулж 165 аялагч, жуулчид ирсэн. Дуу хуур, өв, соёлын өлгий нутгийн бренд болсон Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадмыг Их газрын чулууны БЦГазарт зохион байгуулж 15 сумын 3200 морин хуурч, уртын дуучид оролцож, зохион байгуулах багийн 1000 хүн, гадаад, дотоодын 41000 хүн үзэж сонирхсон. Адаацаг сумын Сүм хөх бүрд байгалийн үзэсгэлэнт газарт Адуучны өв соёлын баяр" эвент арга хэмжээг зохион байгуулж 4 аймгийн 72 адуучин залуус оролцож, 900 гаруй зочид төлөөлөгчид үзэж сонирхсон. Нийт 4 эвент арга хэмжээнд 42583 гадаад, дотоодын жуулчид ирсэн. | 100 |
| 7 | Нутгийн иргэдэд түшиглэсэн жуулчин хүлээн авах малчин өрхийн нэгдсэн сүлжээг бий болгож дэмжлэг үзүүлэх | Хамрагдсан малчин өрхийн тоо | | Тоо | - | 30 | 2023 онд Их газрын чулуунд Хишигтэн говь, Сайнцагаан сумын төвд Оточ өргөө, Сайхан-Овоо сумаас хойш Бүүрцэгт 1 гэр буудал байгуулагдаж, аймгийн хэмжээнд 16 гэр буудлын мэдээллийг Dindgovi travel апплекейшнд оруулсан. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчин хүлээн авах малчин өрх, нөхөрлөлийг дэмжих ажлын хүрээнд Говь-Угтаал сумаас Их газрын чулуу хүртэл Их хишигтэн говь морин аялал зохион байгуулж 16 малчин өрхийн 55 морьтой аялагч, Говь-Угтаал сумд Боржигон найр өв соёлын арга | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэмжээг зохион байгуулж 8 малчин өрхийн 38 хүн оролцож, нийт 24 малчин өрхийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцуулсан. | |
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 2.* Газрын харилцаа, барилга, хот байгуулалт** | | | | | | | | |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:1.* Барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | 2024 он гэхэд 15 сумыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгоно. | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумын тоо | | Тоо | 5 | 14 | 2023 оны жилийн эцсийн байдлаар Сайнцагаан, Өлзийт, Гурвансайхан, Адаацаг, Хулд, Луус, Өндөршил, Баянжаргалан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Дэрэн, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг боловсруулж, батлуулах | Зургийн даалгаврын тоо | | Тоо | 4 | 13 | 2023 онд Цагаандэлгэр сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг дүрмийн дагуу боловсруулж, ГЗБГЗЗГ-ын холбогдох албан тушаалтнуудаар хянуулан, аймгийн Засаг даргаар батлуулж захиалагч байгууллагад хүргүүлсэн. | 100 |
| | 2 | Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | Тухайн жилд хөрөнгө нь шийдвэрлэгдсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тоо | | тоо | 5 | 1 | 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад Цагаандэлгэр сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний зардал 100,0 сая төгрөгийг тусгуулсан. Ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг “Сонголт дизайн” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна. | 100 |
| Зорилт | 2 | Ус хангамж, ариутгах татуурга, барилга байгууламжийг 6 суманд бий болгох | Сумын тоо | | тоо | 3 | 8 | “Сумын хөгжил инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” тус аймгийн Луус суманд хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгч “Бурхант хясаат” ХХК 3,995.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж 2022 онд улсын төсөвт 1,050.0 тэрбум төгрөг батлагдаж 50м3 цэвэрлэх байгууламжийн бетон цутгалтын ажил, био цөөрөм, гүний худаг, усан сангийн байгууламж, ус түгээх байрны ажлууд хийгдсэн. 2023 онд 1,043.7 тэрбум төгрөг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | батлагдаж гадна цэвэр усны шугам сүлжээний ажил хийгдсэн тухайн оны төсвийн гүйцэтгэл 100 хувьтай. | |
| Арга хэмжээ | 1 | 6 сумын усан хангамж, ариутгах татуурга, барилга, байгууламжийн ажлын зургийн даалгавар батлуулах | Батлуулсан ажлын зургийн даалгаврын тоо | | тоо | 3 | 9 | Хэрэгжээгүй | 0 |
| | | | Хүлээн авсан ажлын зураг, төсвийн тоо | | тоо | 10 | 15 | Өлзийт сумын төвийн жишиг гудамж тал зураг төсвийг "Цолмон-Арт" ХХК орон нутгийн хөгжлийн сангийн 47,03 сая төгрөгөөр гүйцэтгэж, магадлалаар батлуулан хүлээлгэн өгсөн. Говь-Угтаал сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төсвийг "Их мянган инженерчлэл" ХХК боловсруулж магадлалаар баталгаажуулах шатандаа байна. | 90 |
| | 2 | "Аймгийн төвийн шинээр баригдах хоногт 3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж, гэр хорооллын 5,57км гадна бохир усны шугам сүлжээ"-ний ажлыг ашиглалтад оруулах | Ажлын гүйцэтгэлийн хувь | | хувь | 40 | - | Аймгийн төвийн хоногт 3000м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга байгууламж, гэр хорооллын 5,57 км бохир усны шугамын ажлыг "Сайн констракшн" ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж туршилт, тохируулгын ажил хийгдэж хэвийн ажиллаж байна. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:* 2 Газрын харилцааны бодлого хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Газрын маргааны асуудал 71 байсныг 2024 онд 35 болгон бууруулна. | Шийдвэрлэсэн газрын маргааны бууралт | | Тоо | 71 | 44 | 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 31 маргаанаас 21 маргааныг шийдвэрлэсэн. | 90 |
| Арга хэмжээ | 1 | Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, шийдвэрлэх | Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өвөлжөө хаваржааны тоо | | Тоо | 0 | 7 | Хилийн цэсийн маргаан болон харьяалах нутаг дэвсгэрийн хилийн гадна иргэн хуулийн этгээдэд газар эзэмших, өмчлөх, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын зааврын дагуу зөрчилтэй олгосон 6 сумын 31 нэгж талбарыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж 21 газрын зөрчлийг арилгаж харьяа сумын Засаг даргын захирамжаар зөрчлийг арилгасан. | 65 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | Аймаг хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах | Тухайн жилд шийдвэрлэсэн маргааны тоо | | Тоо | 0 | 3 | Аймаг хоорондын хил дамнан олгогдсон 3 өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэх талаар Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргад албан тоот хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй болно. | 100 |
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 3.*** **Аймгийн эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, сумдын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангаж, хяналтыг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримтлан аймгийг гадаадад төлөөлөн, гадаад ажил арга хэмжээг оновчтой төлөвлөх, үр дүнтэй зохион байгуулна.*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөрөнгө оруулалт 500 сая төгрөг байсныг 2024 он гэхэд 20 дахин нэмэгдүүлнэ. | Хөрөнгө оруулалтын хэмжээ | | Сая.төг | 500.0 | 7,000.0 | 2023 онд орон нутгийн хэмжээнд 9 төсөл, хөтөлбөр шинээр нэмэгдэн хэрэгжиж нийт 15 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 3,461,816,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Гадаад хамтын ажиллагаатай муж, хот, олон улсын төслийн байгууллагын тоог нэмэгдүүлэх | Нэмэгдүүлсэн улс, орнуудын муж, хотын тоо | | Тоо | 2 | 5 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур хот, Япон Улсын Эхиме мужийн Сейёо хот, Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Гуяан хоттой хамтын ажиллагааны баримт бичиг байгуулан ажиллаж байна. Оросын Холбооны Улсын Красноярск мужтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулахаар хоёр тал гэрээний төсөлд санал солилцож байна. | 100 |
| | | | Шинээр нэмэгдсэн олон улсын төслийн байгууллагын тоо | | Тоо | 7 | 10 | Энэ онд хөдөө аж ахуйн салбарт "Дундговь-Бэлчээрийн нөхөн сэргээлт", "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг", төмс, хүнсний ногоо дэмжих SHEP хөтөлбөр, боловсролын салбарт сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарыг чадавхжуулах "Зуны гэр цэцэрлэг", "Бага ангийн сурагчдын хоцрогдол арилгах зуны сургалт явуулах бэлтгэх хангах" хөтөлбөр, байгаль орчин хамгааллын чиглэлээр "Харганы үр тариалах" төсөл, "Эко хувин" төсөл, "Орон нутгийн агаарын чанарын хяналт -шинжилгээний сүлжээг сайжруулах" төсөл, эрүүл мэндийн салбарт "Сүрьеэгийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хавьтлын үзлэг төсөл" нийт 9 төсөл, хөтөлбөр шинээр нэмэгдэн хэрэгжсэн. | |
| | 2 | БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуянг хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтарсан ажил, арга хэмжээ зохион байгуулах | Тухайн жилд зохион байгуулах арга хэмжээний тоо | | Тоо | 0 | 2 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Баяннуур хотод аймгийн төлөөлөгчид ажиллаж ногоон байгууламж, эрүүл мэнд, ингэн сүүний фермийн үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан. Айлчлалын хүрээнд Баяннуур хотын эмнэлэгтэй хамтарсан үзлэг зохион байгуулахаар ажиллаж байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Гуяан хотод аймгийн төлөөлөгчид эрүүл мэнд, боловсрол, ногоон байгууламж, төрийн бус байгууллагын чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор айлчлал хийв. Айлчлалын үр дүнд Гуяан хотын Дахам төрийн бус байгууллагын эрүүл мэндийн үзлэгийг Дэлгэрцогт сумд зохион байгуулсан. Гуяан хоттой хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчийг дадлагажуулах хөтөлбөрт хамруулсан. Санамж бичгийн хүрээнд нийт 4 арга хэмжээ зохион байгуулсан. | 100 |
| | 3 | Төрийн албан хаагчдыг Гадаадад сургах, туршлага судлах арга хэмжээнд хамруулах | Тухайн жилд хамрагдсан албан хаагчдын тоо | ОНТ 38.1 сая | Тоо | 21 | 30 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Баяннуур хотод 13, Япон Улсад 10, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанси мужид 6, Америкийн Нэгдсэн Улсад 1, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуяан хотод 5, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Хөх хотод 3, нийт 70 төрийн албан хаагчийг туршлага судлах арга хэмжээнд хамруулсан. | 100 |
| | **Үндсэн чиг үүргийн нэр: 2. Аймгийн хэмжээний нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, сургах, давтан сургах, мэргэшүүлэх, сонгон шалгаруулах, нийгмийн баталгааг хангах, төрийн албаны хууль, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах, дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ. | Тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа ТАХ-ийн дундаж хувь | | Хувь | 62 | 65 | Аймгийн хэмжээнд нийт 3270 төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 67 хувь буюу 2190 нь 3-аас дээш жил ажилласан төрийн албан хаагч ажиллаж байна. | 98 |
| | | | Дутагдалтай мэргэжлийн | | Хувь | 64.9 | 80 | "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд аймаг орон нутгийг хөгжүүлэхэд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсон хүчний хангалтын хувь | | | | | зайлшгүй шаардлагатай өндөр чадамж бүхий боловсон хүчнийг салбар бүрд тасралтгүй бэлтгэж 2020 оны байдлаар 64.9 хувтай байгаа боловсон хүчний хангалтыг 2025 онд 85 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Зорилтын хүрээнд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 98 оюутныг гэрээгээр бэлтгэн 2023 оны байдлаар боловсон хүчний хангалт 78 хувьд хүргээд байна. | |
| Арга хэмжээ | 1 | Орон нутагт хэрэгцээтэй боловсон хүчнийг бэлтгэх | Гэрээ байгуулсан оюутны тоо | ОНТ 42.2 сая | Тоо | 10 | 40 | "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд ХААИС, ШУТИС, Глобал удирдагч их сургууль, Мандах бүртгэл дээд сургуульд суралцаж байгаа төгсөх курсийн 6 оюутан, Глобал удирдагч их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд орон нутагт нэн шаардлагатай байгаа сувилагчийн дутагдлыг арилгах зорилгоор "Сувилагч хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж 25 оюутан, төрийн албан хаагчийг сувилагчаар бэлтгэн сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэн гэрээ байгуулан бэлтгэж байна. ТХДЖТМУ-ын Консерваторын ЕБС-ийн ардын бүжгийн ангид суралцаж буй 5 сурагчтай орон нутагт ажиллах гэрээ байгуулан ТХДЖ-т бүжигчин бэлтгэх гэрээг байгуулан ажилласан. 2023-2024 оны хичээлийн жилд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа Хөдөө аж ахуй, эрүүл мэнд, соёл урлаг, санхүүгийн салбарт суралцаж байгаа 37 оюутантай гэрээ байгуулан бэлтгээд байна. | 90 |
| | 2 | Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг авсан төрийн албан хаагчийн тоо | ОНТ 266.2 сая | Тоо | 0 | 150 | 2023 онд "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд:<br>• Төрийн албанд тогтвор суурьшил үр бүтээлтэй ажиллаж байгаа 9 төрийн албан хаагчид гэр, байр орон сууцны дэмжлэг - 77,5 сая төг,<br>• Эрүүл мэндийн тусламж дэмжлэг нэн шаардлагатай 4 төрийн албан хаагчид 14.0 сая төг, төрийн албан хаагчийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төрийн албан хаагчийг хамруулж 4.9 сая төг,<br>• Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж 9 сумын ЗДТГ, Тусгай чиг үүргийн 5 байгууллагад 53,4 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж<br>• Магистарт суралцаж байгаа 46 төрийн албан хаагчийн сургалтын төлбөрт 40.8 сая төгрөг,<br>• Төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг 8 удаа зохион байгуулж 83,3 сая төгрөг, төрийн албан хаагчийг гадаад туршлага судлах ажлын хүрээнд 48 төрийн албан хаагчийг хамруулж 133.5 сая төгрөг нийт 153 төрийн албан хаагчийн сурч хөгжих, ажиллаж амьдрах орчин нөхцөл нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэсэн. | |
| | 3 | Төрийн албан хаагчдыг тогтмол сургалтад хамруулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | ОНТ 4.9 сая | Тоо | 1600 | 1800 | Удирдлагын академийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 15, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад 12, төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 13, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч тус тус улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хамруулаад байна. Алсын хараа 2050 сургалтыг Удирдлагын академитай хамтран орон нутагт танхимаар зохион байгуулж 200 төрийн албан хаагчийг хамруулж, цахимаар 2000 төрийн албан хаагчид, иргэд хөдөлмөрчдийг хамруулсан. Удирдлагын академитай хамтран орон нутагт "Төлөвлөлт ба төсөвлөлт" сургалтыг танхимаар зохион байгуулж орон нутгийн удирдах болон гүйцэтгэх 200 албан хаагчийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Үндсэн чиг үүрэг: 3 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох*** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Ил тод байдлын аймгийн үнэлгээний үзүүлэлтийг 2019 онд 75 хувьтай байгааг 2024 онд 87 хувьд хүргэнэ. | Ил тод байдлын үзүүлэлт | | хувь | 75 | 84 | Аймгийн болон сумдын вэб сайтыг шинэчлэн ил тод байдлын хэрэгжилтийг эрчимжүүлснээр Шил ажиллагааны хүрээнд ЦХХХЯамнаас хийсэн үнэлгээгээр 88.88 хувийн үнэлгээтэй байна. | 100 |
| | 1 | Агентлагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, зөвлөн туслах | Тухайн жилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо | | Тоо | 2 | 8 | Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагийг вэб сайттай болгох, ил тод байдлын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлж үнэлгээ хийх, зөвлөн туслах чиглэлээр 1 удаа, цахимаар мэдээлэл зөвлөгөөг 4 удаа, арга зүйгээр хангах сургалтыг 3, нийт 8 удаагийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. | 100 |
| | 2 | Сумдын ЗДТГ-ын болон төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, зөвлөн туслах | Тухайн жилд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоо | | Тоо | 2 | 4 | 4 сумд зөвлөн туслах үйлчилгээг газар дээр нь үзүүлж, цахимаар зөвлөн туслах сургалт, үйлчилгээг 4 удаа, танхимаар 1 удаагийн сургалт нийт 6 удаа зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | 100 |
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 4*** **Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдал** | | | | | | | | |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 1.*** **Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | Хэрэгжилтийн хувь | | Хувь | 65 | 80 | Батлан хамгаалах хууль тогтоомжийн биелэлтэд хяналт, шалгах явуулах тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/209 дүгээр захирамжийн биелэлтийг хангаж сумдын цэргийн үүргийн биелэлтэд хяналт шалгалтыг явуулж зөрчил дутагдлыг газар дээр арилгах арга хэмжээг авч ажилласан. 2023 оны 1, 2 дугаар ээлжээр цэрэг татлагыг бүх сумдад зохион байгуулж ЗХЖШ-аас өгсөн хяналтын тоог бүрэн биелүүлсэн. Зэвсэгт хүчний 102 жилийн ойн, чөлөөлөх дайны 78 жилийн ойн баярын арга хэмжээг 03 дугаар сард 9-н арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. "Дөл" цогцолбор тэмцээнийг ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 4 дүгээр сард зохион байгуулж 150 сурагчдыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамруулсан. Монгол хурандаа нийгэмлэгтэй хамтран 03 дугаар сарын 07-ний өдрийн “Бидний бахархал” төслийг хэрэгжүүлэх сурталчилгааны үйл ажиллагаа лекц уншиж, чөлөөт ярилцлага хэлбэрээр зохион байгуулж Сайнцагаан сумын ЕБС-ийн дунд ахлах ангийн, МСҮТ-ийн сурагчид, Хулд сумын ЕБС-ийн дунд ахлах ангийн, Цэргийн насны залуучууд зэрэг 170 гаруй иргэдийг хамруулав. 2022 оны нэг, хоёрдугаар ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдан албаа хааж халагдаж ирсэн түрүүч, байлдагчдыг аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, ЗХ-ний 278 дугаар анги, Цагдаагийн газартай хамтран “Ажлын байрны боломж, залуучуудад олгож буй хөдөлмөрийн дэмжих сангийн хөнгөлөлт, зээл” сэдвээр сургалт явуулсан. Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламж, Онцгой байдлын газруудад Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний чиг үүрэг, “Батлан хамгаалахын багц хуулиуд, Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль”-ийн заалтуудаар ухуулга сурталчилгааг явууллаа. Нийт 3 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж 215 иргэнийг хамруулсан байна. “Оюутан-цэрэг” сургалтад Дундговь аймаг дахь Политехник коллежоос 5 оюутныг сонгон шалгаруулж амжилттай хэрэгжүүлсэн. Дайчилгааны тухай хууль 18.1.1, 1.2-д заасны дагуу “Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө” “Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөө”- тодотгол хийж томилгоожуулан “Улсын дайчилгааны даалгавар”-ын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын даалгаврыг тодотгож заасан хугацаанд Цэргийн штабтай иpж нийлсэн. Цэргийн штабаас зохион явуулж үйл ажиллагааг Зэвсэгт хүчний төв хэвлэл “Соёмбо” сонин, аймгийн “Засаг даргын Тамгын газар сонсож | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байна” facebook хаягуудаар, Цэргийн штабын dundgovi@mod.gov.mn, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар bolovsrol@dundgovi.mn, ЗХ-ний Дуулга студи soyombo@mod.gov.mn, сурталчлан ажиллаж байна. | |
| Арга хэмжээ | 1 | Цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулах | Хяналтын тооны биелэлтийн хувь | | хувь | 90 | 96 | “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам” аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны А/552 дугаар захирамжийн дагуу Дундговь аймгийн 2023 оны цэргийн бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 03-аас 02 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Аймгийн 18-60 насны цэргийн үүрэгтний хамрагдалт 87%-тай бүртгэлд хамрагдсан. | 100 |
| Зорилт | 2 | 2020 онд аймгийн нийт өрхийн 38.1 хувь нь угийн бичиг хөтөлж байгааг 2024 онд 24 хувиар нэмэгдүүлнэ. | Угийн бичгээ хөтөлсөн өрхийн эзлэх хувь | | Хувь | 38.1 | 56.1 | Аймгийн хэмжээнд шинээр 853 өрх бичвэрээр болон цахимаар угийн бичиг хөтөлж нийт өрхийн 46.4 хувь буюу 6906 өрх угийн бичиг хөтөлж өмнөх оноос 8.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн угийн бичиг хөтлүүлэх ажлын хэсгийн гишүүд угийн бичгийн уралдааныг зохион байгуулж 6 сумын 15 угийн бичгийг дүгнэсэн. 1-4 түвшин тус бүрт шалгаруулалт хийж байр эзлүүлэн алдаршуулсан. Уламжлалт аргаар хөтөлсөн Монгол улсын гавьяат эмч Хасын гэр бүл, хүү | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Баярсанаа Чимэдийн удмын 9-н үеийн угийн бичгийг Музейн Бүртгэл мэдээллийн санд бүртгэсэн. | |
| Арга хэмжээ | 1 | Иргэдийн угийн бичиг хөтлөх мэдлэг, чадварыг дээшлүүлэх | Сургалт, мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо | | Тоо | 8149 | 11149 | Иргэдийн угийн бичиг хөтлөх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Соёл, урлагийн газраас, сумдын соёлын байгууллагуудаас танхимын болон цахимаар 32 удаагийн сургалтыг зохион байгуулж Сайнцагаан сум 2197, бусад сумд 3478, нийт 5675 иргэн хамрагдлаа. Манлайлан ажилласан Цагаандэлгэр сумын соёлын төв сургалт, мэдээллийг 6 удаа хүргэж "Угийн бичиг хөтлөх өрхийн дэвтэр" зөвлөмж бэлтгэн хэвлүүлж, өрхүүдэд тарааж нийт 360 иргэнийг тайлант үзэсгэлэнг 1 удаа зохион байгуулж 46 өрхийн 238 иргэн, Эрдэнэдалай сум угийн бичгийн хөтлөлтийн цахим программын сургалтыг явуулж 8 өрхийн 52 иргэнийг хамруулсан. Хулд сумын Соёлын төвийн хамт олон бусдыг манлайлан сумын Засаг даргатай хамтран ажиллаж ОНХСангийн 20 сая төгрөгөөр "Удмын хэлхээ" угийн бичгийн апликешн хийлгэлээ. Мөн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газраас Угийн бичиг хөтлөлтийн цахим программын сургалтад Орон нутгийн хөгжлийн сангаас 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Дэлгэрхангай сум google forms ашиглан угийн бичиг хөтлөлтийн судалгааг авсан. | 60 |
| | 2 | Угийн бичиг хөтлөх ажлын үр дүнг үнэлж, дүгнэх | Дүгнэх үйл ажиллагааг зохион байгуулсан эсэх | | Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Өндөршил, Сайхан овоо, Эрдэнэдалай, Баянжаргалан Дэлгэрцогт сумын соёлын төвүүд Угийн бичигтэн удмынхан" уралдааныг сумын хэмжээнд зохион байгуулж уралдаанд 334 угийн бичгийн материалыг хүлээн авч шалгаруулж 12 айл өрхөд "Батламж" олгосон. Угийн бичигтэн Удмынхан аймгийн уралдаанд 6 сумын 15 өрхийн материалыг хүлээн авч угийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулах ажлын хэсэг хуралдаж шалгаруулалтыг хийж 1 дүгээр түвшинд хөтөлсөн 3 өрх, 2 дугаар түвшинд хөтөлсөн 2 өрхийг тус тус шалгаруулсан. | |
| | **Үндсэн чиг үүргийн нэр: 5 Хүн амд боловсролын үйлчилгээ үзүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Сургалтын чанарын үнэлгээний дунджийг 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 49 хувьд хүргэнэ. | Боловсролын чанарын үнэлгээ | | Хувь | 39.1 | 47 | БШУЯ, Боловсролын үнэлгээний төвөөс аймгийн 2023 оны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгалтын үнэлгээ 51.3 хувьтай шалгагдсан өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх | СӨБ-ын хамран сургалтын хувь | | Хувь | 72.5 | 75 | Сургуулийн өмнөх боловсролд 4365 хүүхэд хамрагдахаас 3540 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 81,1 хувьтай байна. Өмнөх оноос 3,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| | 2 | Шаардлагатай суманд шинээр цэцэрлэгийн барилга барих | Тухайн жилд шинээр ашиглалтад орсон цэцэрлэгийн тоо | | Тоо | 2 | 3 | 2023 онд 2 цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөснөөс Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн барилга 100 хувь, Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэй. | 100 |
| | | | Хөрөнгө нь шийдвэрлэгдсэн цэцэрлэгийн тоо | | Тоо | 2 | 1 | Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг "Энх баялаг констракшн" ХХК 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн хүчин чадалтай барилгын ажил хийгдэж байна. Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилгын ажлыг улсын төсвийн 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгыг "Ашид бьюлдинг" ХХК гүйцэтгэж байна. | |
| | 3 | Шаардлагатай сумдад хувилбарт сургалтыг зохион байгуулах | Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо | | Тоо | - | 350 | 2023 оны 6-7 дугаар сард Эрдэнэдалай, Гурвансайхан, Хулд, Луус, Дэрэн, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өлзийт сумдын зуны гэр цэцэрлэгт 14 багш ажиллаж, ахлах бүлэгт-9, бэлтгэл бүлэгт-62, холимог бүлэгт-125 нийт 196 хүүхэд хамрагдсан нь малчдын хамрагдвал зохих хүүхдийн 79.6 хувийг хамруулж сурч хөгжих хэрэгцээг хангасан үр дүнтэй ажил болсон. | 78 |
| | | | Шинээр нэмж ашиглалтад оруулсан гэр | | тоо | 5 | 1 | Энэ хичээлийн жилд Эрдэнэдалай сумын цэцэрлэг 2 гэр цэцэрлэгийг авч ашиглалтад оруулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цэцэрлэгийн тоо | | | | | | |
| | 4 | ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх | Бага, суурь боловсролын хамран сургалтын хувь | | Хувь | 91.6 | 95.5 | Бага, суурь боловсролын хамран сургалт 96,2 хувьтай. Энэ нь өмнөх оноос 1,1 хувиар өссөн байна. Нийт 6-14 насны 8296 хүүхэд хамрагдахаас 7945 хүүхэд хамрагдаж хамран сургалтын хувь 96.2 хувь байна. | 100 |
| | 6 | Шаардлагатай сумдад шинээр сургуулийн барилга барих | Шинээр ашиглалтад орсон сургуулийн тоо | | Тоо | 2 | 2 | 2023 онд 2 сургуулийн барилгыг 50 хувьтай гүйцэтгэхээр төлөвлөж, Сайнцагаан сумын Говийн-Ирээдүй цогцолбор сургуулийн барилга 80 хувь, Хүмүүнлэг сургуулийн барилга 45 хувийн гүйцэтгэлтэй байна. | 0 |
| | 7 | Сургууль бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим, байгалийн ухааны хичээлийн кабинетыг байгуулах | Байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхимын тоо | | Тоо | - | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн танхимыг 2022 онд 6 сургуульд байгуулсныг 2023 онд 5-р нэмэгдүүлж, нийт ерөнхий боловсролын 19 сургуулийн 11 буюу 57.8%-д хүүхэд хөгжлийн танхим байгуулж, үйл ажиллагаа нь тогтмолжуулан ажиллалаа.<br>Хөгжлийн танхимыг сургуульд-4, дотуур байранд 5, насан туршийн боловсролын төвд 2 тус тус байгуулсан байна. | 85 |
| | | | Байгуулсан байгалийн ухааны кабинетын тоо | | Тоо | 3 | 16 | Энэ хичээлийн жилд байгалийн ухааны 3 кабинетийг гэрчилгээжүүлээд байна. Эрдэнэдалай сум Мобиком корпорацийн “SMART EDUCATION 3” төслийн хүрээнд “Тэгш хүртээмжтэй боловсролыг хүүхэд бүрд хүргэх” зорилготой байгалийн ухааны 120 сая төгрөгийн өртөгтэй Дижитал ангитай болж хичээл сургалтаа тохилог иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан ангид хичээллэхэд бэлэн болсон. Дэрэн сумын сургууль /10.297.43/ төгрөгийн үнэтэй “Лабораторийн тоног төхөөрөмж” болох химийн хичээлийн татах шүүгээг Green Chemistry LLC – Грийн Химистри ХХК- аас авч химийн кабинетаа гэрчилгээжүүлээд байна. Сайхан овоо сумын сургууль орон нутгийн санхүүжилтээр байгалийн ухааны иж бүрэн кабинетыг ашиглалтанд оруулахад бэлэн болгож аймгийн хэмжээнд байгалийн ухааны нийт 14 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | кабинеттай болж хичээл сургалтыг үр дүнтэй явуулах боломж бүрдлээ. 71.4% | |
| | 8 | Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх | Гэрээ байгуулсан оюутны тоо | | Тоо | - | 2 | Аймгийн боловсролын салбарын 41 байгууллагаас 2022-2024 онд дутагдалтай байгаа багш нарын судалгааг авч, нэгтгэн ЕБС-уудад 2022 онд 50, 2023 онд 17, 2024 онд 17 мэргэжлийн багшийн дутагдал үүсэх судалгаа гараад байна. Энэ 2023 онд БШУГ-ын хоол үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн, Дэрэн сумын цэцэрлэгийн туслах багш нийт 2 албан хаагчийн сургалтын төлбөрт 4,5 сая төгрөгийг аймгийн хүний нөөцийн хөтөлбөрөөс зарцуулахаар шийдвэрлэлээ. 2021 онд 3 оюутан, 2022 онд 6 оюутан, 2023 онд 2 оюутантай гэрээ байгуулан, нийт 11 болж, 2022 онд дутагдалтай байсан 50 багшийг 56 хувиар бууруулаад байна. | 100 |
| | 9 | Гадаад хэл болон байгалийн ухааны судлагдахууны багш нарыг гадаад улсад болон дотоодод урт хугацаанд мэргэжил дээшлүүлэх | Мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо | | Тоо | 4 | 10 | "MC Children's Books"-ийн ИБУИВУ-д томилолтоор Мандал сургуулийн гадаад хэлний багш Ц.Ариунтунгалаг Англи дахь "Royal Holloway University of London" үндэсний их сургуульд туршлага судалсан. Туршлага судалсны үр дүнд багш нартаа 2 удаагийн сургалт явуулж мэргэжлийн 35 багшид арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлыг эхлүүлээд байна. Эрхүүгийн Үндэсний Судалгааны Техникийн Их Сургуульд орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх зуны сургалтад Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулиас 2, Баянжаргалан, Дэрэн, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 4, нийт 6 багш "Орос хэлний сургалтад орчин үеийн дэвшилтэт технологийг хэрэглэх арга зүй" сургалт, Оросын Сибирийн бүс нутгийн өв соёл, зан заншилтай танилцаж 21 хоног суралцаад ирлээ. Багш нарын заах арга зүй, ур чадварт ахиц, өөрчлөлт гарч өдөр тутмын ээлжит хичээлдээ арга зүйг туршин хэрэгжүүлж байна. Мөн Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Орос хэлний олимпиадад Цэгцбилиг сургуулийн багш Д.Аравхаан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шилдэг багш, сурагч Б.Цэвээнсүрэн Э.Номин-Эрдэнэ нар ОХУ-д хүссэн мэргэжлээрээ 100 хувийн тэтгэлэгтэй суралцах эрх авлаа. Жайка олон улсын байгууллагын Үдийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд захирал, мэргэжилтэн, дарга 6 хүн, хичээлийн судалгааны чиглэлээр Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран Япон улсад Мандал сургуулийн 6 багш, нийт 19 багш, удирдах ажилтан гадаад улсад мэргэжлээ дээшлүүлээд байна. Үдийн хоол төслийн хэрэгжилтэд орон нутгийн дэмжлэг эрчимжиж, улсын хэмжээнд загвар аймаг болох зорилтыг тавин ажиллаж байна. Судалгааны үр дүнд аймгийн хэмжээнд Засаг даргын санаачилга санхүүжилтээр 1-5 дугаар ангид "Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 5000 орчим сурагчид хамрагдаж байна. | |
| | 10 | 12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн баримжаа олгох сургалт, зөвлөгөө, сорилыг үе шаттай зохион байгуулах | ЭЕШ-ын 10 хичээлийн дундаж оноо | | Оноо | 498,4 | 504 | Боловсролыг дэмжих жилийн ажлын хүрээнд Оюунлаг сургууль, МУБИС-тай хамтран багш нарын мэдлэг чадварыг ахиулах 3 удаагийн сургалтыг аймгийн хэмжээний суурь бүрэн дунд боловсролын мэргэжлийн багш нарыг хамруулан зохион байгуулсан. Мөн сурагчдаас 6 удаагийн цахим болон танхимын сорилыг авч үр дүнг тооцон ажилласны үр дүнд элсэлтийн ерөнхий шалгалтын 10 хичээлийн дундаж оноо 2023 онд 10 судлагдахууны аймгийн дундаж оноо 507.5-тай шалгагдаад байна. Энэ нь зорилтот хүрэх түвшнээс 3,5 оноогоор ахисан үзүүлэлт байна. Энэ нь зорилтот хүрэх түвшнээс 3,5 оноогоор ахисан үзүүлэлт байгаа бөгөөд монгол хэл, математик, физик, нийгмийн хичээлүүдийн дундаж оноо улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй шалгагдсан. | 100 |
| | 11 | Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | | Хувь | - | 80 | Өнгөрсөн 2022-2023 оны хичээлийн жилд буюу эхний хагас жилд "Чадварлаг багш" хөтөлбөрийн хэрэгжилт, төлөвлөлтийг сургалтын 41 байгууллагаас авч нэгтгэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүгнэхэд 86.7 хувьтай хэрэгжиж, 10 сард сумдад ажилласан "Зөвлөн туслах баг"-ийн гишүүд цэцэрлэг, сургуулиудад хэрэгжилтийг дахин эрчимжүүлсний үр дүнд хэрэгжилт 87.2 хувьтай дүгнэгдлээ.<br>Чадварлаг багш хөтөлбөрийн багшийн онолын мэдлэгийг дээшлүүлэх зорилтыг аймгийн Эрдэнэдалай, Гурвансайхан, Сайнцагаан сумын ЭДЦС, Цэгц билиг, Мандал сургуулиуд үр дүнтэй хэрэгжүүлснээр элсэлтийн ерөнхий шалгалтын дүн өмнөх оноос 4 хичээлийн гүйцэтгэл 1,36-12,46 оноогоор ахиж, Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрхангай, Адаацаг, Баянжаргалан, Дэрэн сумд багшийн хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд санаачилгатай ажиллан багшийн хөгжлийн төв байгуулан, Баянжаргалан, Дэлгэрхангай, Цэгц билиг, ГИЦС багш нарын улсын төрөлжсөн олимпиадад багш суралцагчдыг амжилттай бэлтгэн, багшаа чадваржуулж, 4 багш 4 суралцагч улсаас эхний байруудад шалгарсан хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж байна. | 100 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 6*** **Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих** | | | | | | | |
| Зорилт | 1 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ. | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | | Хувь | 85.0 | 86.0 | Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 12 нэр төрлийн 2,4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 88,2 хувьтай байна. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Сумдын эрүүл мэндийн төвүүдийг мобайл технологиор хангах | Хангагдсан сумдын тоо | | Тоо | 4 | 4 | Адаацаг сумын эрүүл мэндийн төвд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 12,0 сая санхүүжилтээр хувь хүний хандив тусламжаар 8,0 сая төгрөгөөр хангагдсан. Ингэснээр нийт 13 сумын эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологитой болсон. | 100 |
| | 2 | Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний дэвшилтэт | Тоног төхөөрөмжийн хангалт | | Хувь | 85.0 | 86.5 | Япон Улсын Засгийн газраас "Ковид-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 128,5 сая | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоног төхөөрөмжөөр хангах | | | | | | төгрөгийн 14 ширхэг спидометрийг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан өглөө. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өндөршил, Хулд сумын эрүүл мэндийн төвүүд хог хаягдал ангилан ялгах путик, ор, өвчтөний хоолны шкаф зэрэг 5 төрлийн 14,5 сая төгрөгөөр, 15 суманд хог хаягдлын автоклавыг 85,1 сая төгрөгөөр, 2 өрхийн эрүүл мэндийн төвд хог хаягдлын автоклавыг 9,6 сая төгрөгөөр тус тус хангасан. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 82,2 хувьтай байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газарт Шуурхай удирдлагын нэгж байгуулах 16,0 сая тоног төхөөрөмжөөр хүлээлгэн өгсөн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн буцалтгүй тусламж 3,9 сая төгрөгийн 35 ширхэг пульсоксиметрийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны эмнэлэгт хуваарилан өглөө. Мөн Уламжлалт анагаах ухааны төв болон Эрүүл мэндийн газарт 6,6 сая төгрөгөөр хогийн автоклав, Зооноз өвчин судлалын төв нь 9,8 сая төгрөгийн аймгийн хэмжээнд нийт 883,2 сая төгрөгийн тоног төхөөрөмж авсан байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 94,2 хувьтай байна. Тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьтай. | |
| | 3 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн автомашины парк шинэчлэлт, багийн эмч нарын унааг үе шаттай хийж, түргэн тусламжийн автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглох | Автомашины хангалт | | Хувь | 90 | 94 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт улсын төсвийн 198,0 сая хөрөнгө оруулалтаар Patrol маркийн автомашин, Нарлаг Монголын тээвэр зууч" Нямхишиг транс" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт 123,0 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон автомашин тус тус хүлээлгэн өглөө. Сайнцагаан, Өлзийт-Мандал өрхийн эрүүл мэндийн төвд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 40,0 сая төгрөгийн үнэ бүхий түргэн тусламжийн үйлчилгээг хүргэх суудлын автомашинаар хангасан. Халдварт өвчин | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судлалын үндэсний төвөөс Луус сумын эрүүл мэндийн төвд фургон автомашин, Өлзийт, Луус сумын эрүүл мэндийн төвүүдэд аймгийн мэргэжлийн хяналтын газраас 2 автомашин Орон нутгийн өмчийн газраас шууд шилжүүллээ. Нийт автомашины хангалт 99,0 хувьд хүрсэн байна. | |
| | | | Тоноглосон автомашин | | Тоо | 1 | 2 | Нарлаг Монголын тээвэр зууч " Нямхишиг транс "ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт 123,0 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон автомашин өглөө. Тоноглогдсон автомашины тоо 6 болсон. | |
| | | | Багийн эмчийн унаа | | Тоо | 1 | 10 | Багийн эмчийн унааны асуудал шийдэгдээгүй болно. | |
| Зорилт | 2 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 2020 онд 83.0 байсныг 2024 онд 85.0 хүргэнэ. | Чанарын үзүүлэлт | | Хувь | 83.0 | 84.5 | Эхний хагас жилийн байдлаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 91,0 хувьтай байна. /Жилийн эцсээр гарна/ | 100 |
| Арга хэмжээ | 1 | Явуулын тусламж, үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь | | Хувь | 29.7 | 32.5 | Иргэдийн 69,6 хувийг явуулын тусламж үйлчилгээгээр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. | 50 |
| | | | Өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилтийн хувь | | Хувь | 26.0 | 29.0 | Аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулагдсан "Иргэдээ сонсъё" уулзалтын үеэр 14 суманд нарийн мэргэжлийн 6 эмчийн үзлэг шинжилгээ оношилгоог хийж алслагдсан сумдын багийн иргэдийг явуулын тусламж үйлчилгээнд хамруулсан. Үзлэг шинжилгээ, оношилгоонд нийт 3526 иргэнийг хамруулж үзлэгээр хоол боловсруулах замын эмгэг 51 хувь, цагаан судлалын өвчин буюу нуруу нугасны шохойжилт 41 хувьтай зонхилж байна. Элэгний хавдар 2, элэгний үүсгэвэр 2, элэгний хатуурал 3, элэгний өөхжилд 19, уушгины өөрчлөлттэй 14 бусад өвчлөл 789 байгааг илрүүлсэн.Хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 9747, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 17558, сүрьеэгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1588, заавал хийх товлолд дархлаажуулалтын урьдчилан сэргийлэх үзлэгээр 4125, улаан бурхан улаануудын нэмэлт дархлаажуулалтын урьдчилан сэргийлэх үзлэгээр 4451 нийт 33344 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүлжилт 30,0 хувь. | |
| | 2 | Хот хоорондын зам дагуу болон алслагдсан сумдад яаралтай тусламжийн цэг байгуулах | Цэг байгуулсан сумдын тоо | | Тоо | 1 | 1 | Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад нийт яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулан тогтмолжуулан ажиллаж байгаа бөгөөд зам тээврийн осол 25, хурц иртэй зүйлд 3, бусдад зодуулсан 3, мотоциклоос унасан 2, явганаас унасан 1 иргэн, нийт 34 хүнд тусламж үйлчилгээ 100 хувь үзүүлсэн. Японы Хүүхдийг Ивээх сантай хамтран Сайхан-Овоо суманд яаралтай тусламжийн цэгийг байгуулан, яаралтай тусламжийн нэн шаардлагатай иж бүрэн 6,2 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжөөр хангасан. 12 сард уул уурхай ихтэй Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвд яаралтай тусламжийн цэгийг байгуулахаар шаардлагатай 38,800 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахаар шийдвэрлэсэн. | 100 |
| | 3 | Олон улсын эмнэл зүйн UP TO DATE программыг эмч бүр ашиглах,алсын зайн оношилгоо, зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлж эмч нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах | Ашиглалтын хувь | | Хувь | 0 | 100 | Олон улсын эмнэл зүйн UP TO DATE цахим платформыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн 100 хувь ашиглаж байна. Эхний хагас жилийн байдлаар алсын зайн оношилгоо, зөвлөгөөг төрөлжсөн нарийн мэргэжлийн төвөөс 6 удаа авсан. | 100 |
| | | | Хангалтын хувь | | Хувь | 45 | 100 | Эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 16,5 сая төгрөгийн үнэ бүхий суурин 15 компьютероор хангаж нийт 56 болсноор эмч нар 100 хувь хангагдсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах | Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлт/ | | Просант имиль | 0 | 0 | 11 сарын байдлаар нийт 639 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 94,6 хувь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрсөн. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. | 50 |
| | | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлт/ | | Промиль | 10.0 | 9.3 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 15,6 промиль байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6,0 промилиор өссөн үзүүлэлттэй байна. Эндэгдлийн дотор нялхсын эндэгдэл 7 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 10,9 промиль байгаа нь урьд оны мөн үеэс 1,3 промилиор өссөн. Осол гэмтлээр 3 хүүхэд эндсэн нь нийт эндэгдлийн 30,0 хувийг эзэлж байна. | |
| Зорилт | 3 | Халдварт бус өвчлөлийн түвшин 2020 оны 7441.5 байсныг 2024 онд 7241.5 болгож бууруулна. | 10000 хүн амд ногдох халдварт бус өвчлөлийн түвшин | | Промиль | 7441.5 | 7291.5 | Халдварт бус өвчлөлийн түвшин 10000 хүн амд 9419,2 ногдож байна. Өнгөрсөн оны мөн үеэс 2137,7 –оор өссөн байна. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх | Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо | | Тоо | 37 | 46 | "Эрүүл мэндийг дэмжигч иргэн, өрх гэр бүл, хамт олон" шалгаруулах болзолт уралдааныг зарлаж журам, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийлээ. "Эрүүл мэндээ дээдлэгч иргэн"-ний тоо аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 47 боллоо. "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" шалгаруулах болзолт уралдааны удирдамжийг хүргүүлснээр эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо 88 болсон. | 100 |
| | | | Хог хаягдлын автоклаваар хангагдсан ЭМБ-ын тоо | | Тоо | 0 | 9 | Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд 19 ширхгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хангагдсан. | |
| | 2 | Хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийг бууруулах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх . | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын хувь | | Хувь | 29.7 | 33.8 | Эрүүл мэндийн байгууллагуудаар нийт давхардсан тоогоор 165640 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 24,1 хувьтай байна. | 100 |
| | | | Эрт илрүүлэг үзлэгийн | | Хувь | 57.8 | 65.0 | Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл 10 сарын байдлаар: | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамрагдалтын хувь | | | | | – Артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 10287 иргэнээс 9539 буюу (92,7%),<br>– Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 10910 иргэн хамрагдахаас 9617 буюу (88,1%),<br>– Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2466 иргэн хамрагдахаас 1781 буюу (72,2%),<br>– Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 7829 иргэн хамрагдахаас 5881 буюу (75,1%) хамрагдаж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 82,0%-тай байна.<br>Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 43, чихрийн шижинтэй 10 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авч эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. | |
| | | | Эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь | | Хувь | 59.4 | 74.4 | Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд болон нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан 2023 онд зохион байгуулах тэмдэглэлт өдрүүдийн сургалт сурталчилгааны төлөвлөгөөг үндэслэн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны календарчилсан нэгдсэн төлөвлөгөөг гарган ажиллаж нийт 456 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан. Мэдээлэл сургалтад давхардсан тоогоор 96[illegible]88 иргэн хамрагдаж нийт хүн ам 2 дахин эрүүл мэндийн боловсрол олгосон байна. | |
| | 3 | Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхыг бүрдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан | Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалтын хувь | | Хувь | 50.0 | 58.0 | Аймгийн хэмжээнд коронавирусын халдварын нийт 121 тохиолдол бүртгэгдэж, коронавируст халдварын тархалт “Ногоон” буюу “тархалт бага тогтвортой” түвшинд байна. 45 дугаар 7 хоногт аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн амбулаториор үйлчлүүлэгчдийн дунд томуу томуу төст өвчин 10,000 хүн амд 47,7 эмнэлэгт хэвтэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх. | | | | | эмчлүүлэгсдийн дунд амьсгалын замын цочмог халдварын тохиолдол 10,000 хүн амд 4,4 байгаа нь томуу, томуу тест өвчний тархалтын түвшин "Идэвхжил түвшин"-д байна. Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис 115 нэр төрөл буюу 89,2 хувийн хангалттай байна. | |
| | | | Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | | Хувь | 78.0 | 85.0 | Сум өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 82,0, Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 94,0 аймгийн хэмжээнд тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьтай байна. | |
| | | | Дархлаажуулалтын хамралтын хувь | | Хувь | 94.4 | 96.0 | Заавал хийх товлолд дархлаажуулалтад 4143 хүүхдийг хамруулж хамралт 94,6 хувьтай байна. | |
| | ***Ерөнхий чиг үүргийн нэр: 10* Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ** | | | | | | | | |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 1*. Газар тариалангийн бодлого зохицуулалт: Газар тариалангийн тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, эрчимжүүлэх** | | | | | | | | |
| Зорилт | 1 | Орон нутгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээний 30 хувийг хангана. | Хангамжийн хувь | | Хувь | 17,7 | 25 | Аймгийн нийт хүн ам буюу жишсэн дундаж хүн амд төмс 222 тн, хүнсний ногоо 179.5 тн тус тус хэрэгцээтэйгээс төмсний 16,1 хүнсний ногооны 4.9 хувийг, нийт 21 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан байна. | 85 |
| Арга хэмжээ | 1 | Төмс тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх | Тариалсан талбайн хэмжээ | | га | 27 | 32 | Төмс 29 га-д тариалсан байна. | 33 |
| | | | Хураан авсан ургацын хэмжээ | | тн | 238 | 290 | 222 тн-ийг хураан авсан байна. | |
| | 2 | Хүнсний ногоо тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх | Тариалсан талбайн хэмжээ | | га | 16,2 | 19,5 | Хүнсний ногоо 22,3 га-д тариалсан байна. | 100 |
| | | | Хураан авсан ургацын хэмжээ | | тн | 131 | 152,6 | 179,5 тн-ийг хураан авсан байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ***Үндсэн чиг үүргийн нэр: 2. Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого зохицуулалт:*** Хүнсний болон хоол үйлдвэрлэлд үнэ цэний болон кластерийн сүлжээг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах | | | | | | | | |
| Зорилт | 1 | Мах сүүн сүүн бүтээгдэхүүний орон нутгийн үйлдвэрлэлийн хэмжээ 2020 онд 325,1 тн байсныг 2024 онд 482,2 тн-оор нэмэгдүүлж хангамжийн хувийг 36,9 хувьд хүргэнэ. | Үйлдвэрлэлийн хэмжээ | | Тн | 325,1 | 432 | Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн 258,8 тонныг үйлдвэрлэж 10,2 хувийг "мал төхөөрөх цэг болон бууз баншны үйлдвэр цехэд нийт 502,3 тонн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж 30 хувийг, сүү, сүүн бүтээгдэхүүн 3,3 мян.л-ийг үйлдвэрлэж 1,4 хувийг, өндөг-78,4 тонныг үйлдвэрлэж 28 хувийг тус тус үйлдвэрлэж хангасан байна. | 100 |
| | | | Хангамжийн хувь | | Хувь | 19,6 | 26,3 | Орон нутгийн үйлдвэрлэлээр нийт 69,6 хувийг хангасан. | |
| Арга хэмжээ | 1 | Үйлдвэр цехэд бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнийг хүн амын хэрэгцээнд нийлүүлэх | Бэлтгэсэн махны хэмжээ | | Тн | 321,4 | 427,0 | Сайнцагаан,Говь-Угтаал суманд үйл ажиллагаа явуулж буй "Мал төхөөрөх" 4 цэгт хонь 21800, ямаа 7200, адуу -40, үхэр-130, тэмээ-14 толгой буюу маханд шилжүүлснээр 487 тн мах бэлтгэж аймгийн болон Улаанбаатар хотын хэрэгцээнд нийлүүлсэн байна. Мөн үйлдвэрийн аргаар 15,3 тн бууз банш үйлдвэрлэж, нийт 502,3 тн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрийн аргаар бэлтгэж боловсруулсан. | 100 |
| | 2 | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх | Нийлүүлсэн сүүний хэмжээ | | Мян.л | 3,7 | 5,0 | Мандалговь Хүнс ХХК үйлдвэрийн аргаар 3000л шингэн сүүг боловсруулж ааруул, 300л ингэний хоормог ариутган стандартын шаардлага хангасан сав баглаа боодолтойгоор хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. | 70 |
| | **Үндсэн чиг үүргийн нэр: 3 Хөнгөн, *Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны* хөгжлийн бодлого, зохицуулалт**: Хөнгөн үйлдвэр, Жижиг, дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ, хоршооны салбарт кластерын сүлжээг хөгжүүлэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2019 онд 17,5 хувь байсныг 2024 онд 23.3 хувьд хүргэнэ. | ДНБ-д эзлэх хувийн өсөлт | | Хувь | 17.5 | 21.7 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2022 оны жилийн эцсийн байдлаар 63,2 тэрбум төгрөг буюу аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд 15,2 хувийг эзэлж байна. 2023 оны үзүүлэлт 2024 оны эхний хагас жилээр гарна. | 90 |
| | 1 | Арьс ширний анхан шатны тордолтын цех байгуулах | Цехийн тоо | | Тоо | 1 | 2 | Адаацаг, Өндөршил сумдад арьс, нэхий элдэх анхан шатны 2 цех байгуулагдсан. 2022 онд 5 цех байсан бол 2023 онд шинээр 2 цех | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | | | | | | | | байгуулагдаж хийт 7 цех бий болсон. Энэ оны борлуулалтын орлого 10,700,000 төгрөг. | 100 |
| | | | Ажлын байрны тоо | | Тоо | 3 | 6 | Шинээр 4 ажлын байр бий болсон. Ингэснээр ажлын байрны тоо 7 болсон. | |
| | 2 | Өлзийт суманд ингэний фермерийн аж ахуйг байгуулж, сүүг үйлдвэр цехэд нийлүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлэх | Саальд хамрагдах ингэний тоо | | тоо | 0 | 120 | Хэрэгжээгүй | 0 |
| | | | Тухайн жилд нийлүүлсэн сүүний хэмжээ | | тн | 0 | 5,5 | | |
| | 3 | Сумдад мал төхөөрөх цех байгуулах | Цехийн тоо | | Тоо | 5 | 9 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сайнцагаан сумын "Дэлгэр номт ундраа" ХХК 90,0 сая, Сайхан-Овоо сумын "Эрхэст Ундраа" ХХК 242,64 сая төгрөгийн санхүүжилт авч "Мал, төхөөрч мах, махан бүтээгдэхүүн ангилж савлах" үйлдвэр, цех байгуулагдсан. | 100 |
| | 4 | Орон нутгийн онцлогтой хоршоодыг байгуулах | Шинээр бий болсон хоршоо | | тоо | - | 4 | ХХААХҮЯамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран Бизнес эрхлэгч нарт хоршоо хөгжүүлэх сан болон хоршооны тухай ерөнхий ойлголт, хоршоо байгуулагдсанаар давуу талын талаарх сургалтыг 4 удаа 173 иргэнд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 98 хоршоо байгаагийн 40% мал аж ахуй түүхий эдийн бэлтгэл, 4% мал, эмнэлгийн үйлчилгээ, 2% модон эдлэл үйлдвэрлэл, 24% ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл 8% хадгаламж, зээл, 17% худалдаа, үйлчилгээ, 5% газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. Эрдэнэдалай сумын Далайн баялаг төгөл хоршоо Далайн шим болон Арвижих гэсэн 2 малчны бүлэгтэй. Бүлгүүд хүнсний ногоо, сүү цагаан идээ, ногоон тэжээл тариалсан. Үүнээс хүнсний ногоо болон сүү, цагаан идээгээ борлуулан хоршооны дундын санд 3,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. | 100 |
| | 5 | Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах | Цэг байгуулагдсан эсэх | | Тийм – 1, Үгүй - 0 | 0 | | Орон нутгийн өмчит Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрээр 180 иргэн, ААН-ийн бүтээгдэхүүнийг борлуулж энэ жилийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэгийг шинээр байгуулан борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх | | | | | борлуулалтын орлого 348.0 сая төгрөг байна. Бизнес хөгжлийн төвд бойжиж буй 20 иргэн, ААН нийт 223.3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна. Бизнес эрхлэгчдийг ажлын байртай болгож, үйл ажиллагааг тогтмолжуулж өгснөөр борлуулалтын орлого өмнөх оноос 220,0 сая төгрөгөөр өссөн. | |
| | | | Тухайн жилийн борлуулалтын орлого | | Сая.төг | 164 | 230 | Тухайн жилийн орлого 571,3 сая.төгрөг байна. | |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:4 Мал аж ахуйн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах:*** Мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, усан хангамжийг сайжруулах, малыг байгаль цаг агаарын эрсдэлээс хамгаалах, тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, малчны орлого нэмэгдүүлэх, малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, бүртгэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 2300 малд нэвтрүүлнэ. | Хамрагдсан хонины тоо | | Тоо | 0 | 1500 | Энэ онд 500 хонинд зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгуулж битүү хөнгөлгөөний аргыг 250 хурга, 20 бяруунд туршиж аймгийн хэмжээнд 1570 малд биотехнологийн ололтыг нэвтрүүлсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх | Бойжуулсан төл | | Тоо | 0 | 700 | Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд өндөр ашиг шимт суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч хээлтүүлэг хийж энэ онд 50 хонинд зохиомол хээлтүүлэг хийхээс 500 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийж аймгийн хэмжээнд нийт 1000 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдсэн. Өнгөрсөн жилийн зохиомол хээлтүүлэг хийсэн 380 эм хонь 85 хувьтай төллөж 232 төл хүлээн авсан. Нийт бойжуулсан төл 732 болсон. | 100 |
| | 2 | Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах | Тухайн жилд ээмэгжүүлж бүртгэлжүүлсэн мал | | Тоо | 21000 | 26000 | Стандартын шаардлага хангасан хуц 6202, ухна 4299 бүгд 10501 хээлтүүлэгчийг ээмэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд бүртгэж байна. | 40 |
| Зорилт | 2 | Талхлагдсан 110,0 мянган га бэлчээрийн талбайг сэргээж, усан | Тухайн жилд сэргээсэн талбайн хэмжээ | | Мян.га | 100,0 | 10,0 | Энэ онд шинээр 40,5 мянган га талбайг нөхөн сэргээсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангамжийг 0.7 хувиар нэмэгдүүлнэ. | Усан хангамж нэмэгдүүлсэн хувь | | Хувь | 50,3 | 50,9 | Бэлчээр усжуулалтыг өмнөх оноос 0,7 хувиар нэмэгдүүлж 51 хувьд хүргэсэн. | |
| Арга хэмжээ | 1 | Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх | Тухайн жилд тэмцсэн талбайн хэмжээ | | Мян.га | 100,0 | 10,0 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн 185 дугаар тогтоол Бэлчээр хамгаалах өдрийг тохиолдуулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/218, А/587 дугаар захирамжаар Улсын төсвийн 167,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан ,Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад 10,0 мянган га бэлчээрийн талбайд үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар, энгийн механик аргаар 30 мянган га бэлчээрийн талбайд, нийт 40,0 мянган га талбайд тэмцсэн. | 100 |
| | 2 | Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах | Тухайн жилд шинээр гаргасан худгийн тоо | | Тоо | 23 | 10 | Улсын төсөв, орон нутгийн төсвийн 1190,4 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан,Говь-Угтаал, Цагаандэлгэр, Луус, Өлзийт сумдад инженерийн хийцтэй 18 худаг, Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад 30 цооног нийт 48 худгийг шинээр гаргаж 72,0 мянган га бэлчээрийн талбайг усжуулсан. | 100 |
| | 3 | Тэжээлийн олон наст ургамал тариалах | Тухайн жилд бэлчээрийн олон наст тариалсан талбайн хэмжээ | | Га | 0 | 3 | Дэлхийн зөн олон улсын байгууллага, малчдын хувийн хөрөнгө нийт 101,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянжаргалан, Гурвансайхан, Луус, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр сумын малчид, Эрдэнэдалай сумын малчдын бүлэг 15,9 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 15,8 тн ургац хураан авсан. | 100 |
| Зорилт | 3 | Айргийг аймгийн брэнд бүтээгдэхүүн болгон баталгаажуулах | Баталгаажуулсан эсэх | | Тийм-1, үгүй-0 | 0 | - | Айрагийн судалгааны ажил хийгдэж Өвөр монголын өөртөө засах орны ажил мэргэжлийн дээд сургуулийн лаборатори хүргүүлж судалгааны дүгнэлт 7-8 сарын | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хугацаанаас хамаарч гардаг тул 2 дугаар сард дүгнэлт гарч баталгаажуулалтын үйл ажиллагаа хийгдэнэ. | |
| Арга хэмжээ | 1 | Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах | Хамтран ажилласан байгууллагын тоо | | Тоо | 0 | 2 | ХААИС, Өвөр монголын өөртөө засах орны хөдөө аж ахуйн ажил мэргэжлийн дээд сургуулийн эрдэмтэд, ШУТИС-ийн багш, судлаачид, Мал аж ахуй биотехнологийн сургуулийн бүтээгдэхүүн судлалын тэнхимийн багш нартай хамтран Дэрэн, Адаацаг, Дэлгэрцогт сумдын малчдад саам болон айрагчны дээжийг авч хамтран ажилласан. | 100 |
| | 2 | Лаборатори судалгааны ажил хийгдэх | Лаборатори судалгаа хийгдсэн тоо | | Тоо | 0 | 5 | Өвөр монголын өөртөө засах орны Хөдөө аж ахуйн ажил мэргэжлийн дээд сургуулийн эрдэмтэд, ШУТИС-ийн багш нартай хамтран Дэрэн, Адаацаг, Дэлгэрцогт сумдын малчдад саам болон айргийн дээжийг зун, намар 2 удаа Өвөр монголын хөдөө аж ахуйн лабораторид хүргүүлсэн. | 40 |
| | ***Үндсэн чиг үүргийн нэр:5 Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх:*** Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, суурь баазыг бэхжүүлэх, шинэчлэх | | | | | | | | |
| Зорилт | 1 | Нийт мал сүргийн 20-с доошгүй хувийг дархлаажуулна. | Тухайн онд дархлаажуулсан малын эзлэх хувь | | Хувь | 16,2 | 21.4 | Шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 3249.6 мянган толгой мал хамруулахаар төлөвлөснөөс 2916 мянган толгой мал хамрагдаж 89.7% гүйцэтгэсэн. | 100 |
| Арга хэмжээ | 1 | Тархвар зүйн судалгаанд үндэслэн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулах | Хамруулсан малын тоо | | Мян.тол | 650.0 | 750.0 | 4 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 748.4 мянган толгой мал хамруулахаас 751.8 мянган толгой мал хамруулж 100% гүйцэтгэлтэй. | 100 |
| | 2 | Малын халдварт, цусны шимэгч, зооноз, эндемик өвчний судалгааг аймгийн мал эмнэлгийн лабораторид хийх | Тухайн жилд судалгаанд хамрагдсан сорьц | | Тоо /мянга/ | 13.0 | 17.0 | Малын халдварт, цусны шимэгч, зооноз, эндемик өвчний 15547 сорьц цуглуулан шинжилгээнд хамруулсан. | 35 |
| | 3 | Сум бүрийг вакцин хадгалах хөргүүртэй болгох | Тухайн жилд хөргүүртэй | ОНТ 38.0 сая | Тоо | 0 | 5 | Энэ онд Сайхан-Овоо, Баянжаргалан, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Хулд сумд 10 сая төгрөгийн үнэ бүхий вакцин хадгалах | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | болсон сумын тоо | | | | | хөргүүртэй болж нийт 13 сум вакцин хөргүүртэй болсон. Гурвансайхан, Дэлгэрхангай сумд хөргүүр авах санхүүжилтийг шийдвэрлэсэн. | |
| | | | | | | | | | 91.74 |
| **Зарцуулсан төсөв-** УТ- 5988.9, ОНТ-470.2, Хувийн хэвшил-46.8 | | | | | | | | | |

Нийт: Ерөнхий чиг үүрэг **: 10,** Үндсэн чиг үүрэг **: 40,** Зорилт: **50,** Арга хэмжээ: **169**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Н.ДЭЛГЭРМАА

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:
ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.СОЛОНГО